

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ,
ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН ТАЙЛАН

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх энэхүү судалгааг Хууль тогтоомжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д “Энэ хуулийн зорилго нь хууль, Улсын их хурлын бусад шийдвэр /цаашид “хууль тогтоомж” гэх/-ийг санаачлан боловсруулах, хууль тогтоомжийн төсөлд тавигдах шаардлагыг тодорхойлох, олон нийтийн оролцоог хангах, Улсын Их хуралд өргөн мэдүүлэх, батлагдсан хууль тогтоомжийг нийтлэх, сурталчлах, түүний хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж заасан зорилгын хүрээнд дараах байдлаар хийж гүйцэтгэв.

Энэхүү үнэлгээний зорилго нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан аргачлалын дагуу үнэлгээ хийж, тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсронгуй болгох санал боловсруулахад оршино.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь 2 зүйлтэй бөгөөд мөн хуулийн 31 дүгээр зүйлд заасан “Нутгийн өөрийн удирдлага дахь иргэний оролцоо”-г олон улсын сайн туршлагад нийцүүлэн иргэдэд хүртээмжтэй, цаг хугацаа, зардал хэмнэсэн байдлаар боловсронгуй болгож өөрчлөлт оруулахад чиглэнэ. Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд “нутгийн өөрийн удирдлага дахь иргэний оролцоо”, “нийтийн өргөдөл”, “цахим оролцооны систем” зэрэг шинэ зохицуулалтыг нэвтрүүлэхээр зорьж байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн зорилт нь иргэд орон нутгийн үйл хэрэгт шууд болон төлөөллийн байгууллагаараа дамжуулан оролцох эрх зүйн үндсийг бүрдүүлэхэд оршдог. Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна” гэж, 59 дүгээр зүйлд нутгийн өөрөө удирдах байгууллагын үндсийг тус тус тогтоосон нь энэхүү хуулийн төслийн үзэл баримтлалтай нийцэж байна.

Сүүлийн жилүүдэд олон улсын түвшинд иргэдийн оролцоог цахим хэлбэрээр өргөжүүлэх чиг хандлага эрчимтэй хөгжиж байгаа бөгөөд НҮБ, OECD, Дэлхийн банк зэрэг байгууллагууд иргэдийн оролцоог ил тод, хүртээмжтэй, хариуцлагатай засаглалын үндсэн нөхцөл гэж үзэж байна.

Парламентын судалгааны хүрээлэнгийн “Орон нутгийн түвшинд иргэдийн оролцоог хангах платформын харьцуулсан судалгаа”-д иргэдийн оролцоо нь бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцын чанарыг сайжруулж, төрд итгэх итгэлийг нэмэгдүүлдэг талаар дурдсан байна. Мөн орон нутгийн хөгжлийн сангийн цахим саналын системийн туршлагаас харахад 2023-2026 онд иргэдийн цахим

саналын тоо тогтвортой өссөн нь иргэд цахим оролцооны механизмыг бодитоор ашиглаж эхэлснийг харуулж байна.

Иймээс энэхүү хуулийн төсөл нь нийгмийн бодит хэрэгцээнд тулгуурласан бөгөөд нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, цахим ардчиллыг хөгжүүлэх зорилготой гэж үзэв.

Тайлан нь дараах бүтэцтэй.

- I. Хуулийн төслийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгох;
- II. Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоох;
- III. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн байдал;
- IV. Үр нөлөөг үнэлж дүгнэлт, зөвлөмж гаргасан байдал.

I. ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТОГТООХ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, 17 дугаар зүйлийн 17.1-17.4 дахь хэсэг, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтад заасан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын 2.2 дахь хэсэгт заасан зургаан шалгуур үзүүлэлтээс дараах шалгуур үзүүлэлтийг сонгон авч хууль тогтоомжийн үр нөлөөг үнэлэв. Үүнд:

1. Зорилгодоо хүрэх байдал;
2. Практикт хэрэгжих боломж;
3. Ойлгомжтой байдал;
4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал;
5. Харилцан уялдаа гэсэн аргачлалуудыг баримтлан үнэлгээ хийв.

II. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООХ

Энэхүү хэсэгт уг хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгээ тогтоож, шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох хэсгийг сонгов. Эдгээр хэсгийг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэх, иргэдийн тэгш хамруулах, шинэлэг байдлыг бий болгож байгаа ач холбогдлоор нь сонгон судлав. Өөрөөр хэлбэл тус хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ иргэдийн цаг хугацааг хэмнэх, зардал гаргахгүй байх үүднээс хуулийн төслөөс шинэлэг зохицуулалтыг бий болгож буй хэсгийг сонгож, тухайн сонгосон хэсгийн үр нөлөөг судалсан болно.

2.1. Зорилгодоо хүрэх байдал

Зорилгод хүрэх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь үнэлэв.

2.2. Практикт хэрэгжих боломж

Практикт хэрэгжих байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь үнэлэв.

2.3. Ойлгомжтой байдал

Ойлгомжтой байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөлд бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцов.

2.4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал

Хүлээн зөвшөөрөгдөх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөлд бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцов.

2.5. Харилцан уялдаа

Харилцан уялдаа буюу бусад хууль тогтоомжтой уялдаж байгаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөлд бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцов.

III. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

3.1. ЗОРИЛГОДОО ХҮРСЭН БАЙДАЛ

/Тохирох шалгах хэрэгсэл: Зорилгод дүн шинжилгээ хийх/

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулж, өөрчлөлт найруулах хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл шаардлагад нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийнэ. Ингэхийн тулд хуулийн төслийн үзэл баримтлал болон орон нутгийн түвшинд иргэдийн оролцоог хангах, шийдвэр гаргах үйл явцад татан оролцуулах платформ – харьцуулсан судалгааны тайлан зэрэг нь хуулийн төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулан судлах замаар дүн шинжилгээ хийсэн болно.

Хуулийн төслийн үзэл баримтлал болон зохицуулалтаас үзэхэд төслийн үндсэн зорилго нь:

1. Нутгийн өөрөө удирдах байгууллагын шийдвэр гаргах ажиллагаанд иргэдийн шууд оролцоог нэмэгдүүлэх;
2. Иргэдийн санаачилгыг цахим хэлбэрээр хүлээн авах эрх зүйн орчныг бүрдүүлэх;
3. Орон нутгийн түвшний шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлэх;
4. Цахим ардчиллын механизмыг хөгжүүлэхэд чиглэж байна.

Парламентын судалгааны хүрээлэнгийн судалгаанд иргэд бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад оролцох боломж нэмэгдэх нь төрд итгэх итгэлийг өсгөдөг талаар дурдсан байна.

Мөн орон нутгийн цахим саналын туршлагаас харахад иргэдийн оролцоо бодитоор нэмэгдэж байгаа нь төслийн зорилго практикт хэрэгжих боломжтойг харуулж байна.

2023 онд 220,656 цахим санал бүртгэгдэж байсан бол 2026 онд 405,821 болж өссөн нь иргэд цахим хэлбэрээр оролцох байдал нэмэгдэж байгааг харуулж байна.

Иймээс хуулийн төсөл нь тавьсан зорилгодоо хүрэх боломжтой бөгөөд нийгмийн бодит хэрэгцээнд тулгуурласан гэж үзэв.

3.2. ПРАКТИКТ ХЭРЭГЖИХ БОЛОМЖ

/Тохирох шалгах хэрэгсэл: Практикт турших/

Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд энэхүү хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх боломжтой эсэх, дагаж мөрдсөнөөр үр дүн хэрхэн гарахыг тодорхойлох зорилгоор олон улсын практик туршлагыг харьцуулсан байдлаар судалсан болно.

Төслийн хэрэгжилтийн боломжийг одоо байгаа цахим дэд бүтэц, төрийн үйлчилгээний систем, орон нутгийн нөхцөл байдалтай харьцуулан үнэлэв.

Монгол Улсад:

- e-Mongolia;
- тоон гарын үсэг;
- төрийн цахим үйлчилгээ;
- төрийн мэдээллийн нэгдсэн системүүд ашиглагдаж байгаа нь төслийг хэрэгжүүлэх техникийн үндэс болж байна.

Хуулийн төслийн 31.5-д нийтийн өргөдлийг дэмжсэн саналыг тоон гарын үсгээр баталгаажуулахаар тусгасан нь:

- саналын үнэн зөв байдлыг хангах;
- давхардал, хуурамч бүртгэлээс сэргийлэх;
- цахим оролцоонд итгэх итгэлийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Практикт турших байдлаар дараах нөхцөлүүдийг авч үзэв.

1. Аймаг, нийслэлд хэрэгжих боломж

Интернет хэрэглээ, цахим үйлчилгээний хүртээмж өндөр бөгөөд иргэдийн интернэт хэрэглээ ч мөн өндөр хөгжсөн тул хэрэгжих боломж харьцангуй сайн байна.

2. Сум, багийн түвшинд

Интернетийн хүртээмж, иргэдийн цахим хэрэглээ харилцан адилгүй тул хэрэгжилт хүндрэх, иргэдийн оролцоо болон цахим платформын хэрэглээнд эрс ялгаа гарах эрсдэлтэй.

3. ИТХ, ИНХ, тэдгээрийн ажлын албаны ачаалал

Олон нийтийн өргөдөл олноор ирэх тохиолдолд учирч болзошгүй эрсдэл:

- хэлэлцэх хугацаа удаашрах;
- техникийн ачаалал нэмэгдэх, үүнээс улбаалан систем гацах, нийтийн өргөдлийн санал, хүсэлт зэрэг дэс дараалал алдагдах;
- хүний нөөц хүрэлцэхгүй болох зэрэг эрсдэлтэй.

4. Туршилтын журмаар хэрэгжүүлэх шаардлага

Эхний шатанд:

- нийслэл;
- томоохон аймаг;
- техник хангамж сайн орон нутагт турших гэсэн дарааллаар үе шаттай хэрэгжүүлэх нь зүйтэй.

Гэвч дараах эрсдэлүүд байж болзошгүй:

- орон нутгийн иргэдийн цахим хэрэглээний ялгаа;
- ахмад настан болон интернетийн хүртээмж сул бүсийн оролцоо буурах;
- ИТХ-ын түвшинд техникийн болон хүний нөөцийн бэлтгэл хангалтгүй байх;
- нийтийн өргөдлийн босго хувийг хэрэгжүүлэхэд хүн ам цөөн суманд хүндрэл үүсэх.

Иймээс төслийг практикт хэрэгжүүлэх боломжтой боловч үе шаттай нэвтрүүлэх, техникийн болон хүний нөөцийн бэлтгэл хангах шаардлагатай гэж үзэв.

3.3. ОЙЛГОМЖТОЙ БАЙДАЛ

/Тохирох шалгах хэрэгсэл: Ойлгомжтой байдлыг шалгах/

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд хууль нь ойлгомжтой, тодорхой, хоёрдмол утгагүй байх шаардлагатай гэж заасан.

Төслийн зохицуулалтыг хэл зүй, хэрэглээний үүднээс шалгахад дараах байдал ажиглагдав.

Эерэг тал:

- “нийтийн өргөдөл” гэсэн нэр томъёо энгийн ойлгомжтой;
- цахим систем ашиглах зохицуулалт тодорхой;
- хүлээн авахгүй байх үндэслэлүүдийг жагсаасан нь хэрэглээнд дөхөм байна.

Тодруулах шаардлагатай хэсэг:

Давхардсан өргөдөл

Нэг асуудлаар дахин дахин өргөдөл гаргах нөхцөл тодорхойгүй байна.

Иймээс ойлгомжтой байдлыг хангах үүднээс:

- нэр томъёоны тайлбар нэмэх;
- хугацааны зохицуулалт оруулах;
- хэрэгжүүлэх журмыг илүү нарийвчлах шаардлагатай гэж үзэв.

3.4. ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДӨХ БАЙДАЛ

/Тохирох шалгах хэрэгсэл: Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийх/

Иргэдийн оролцооны талаарх олон улсын болон үндэсний судалгааг харьцуулан үнэлэв.

Парламентын судалгааны хүрээлэнгийн судалгаанд:

- цахим оролцоо;
- цахим санал;
- цахим зөвлөлдөх ажиллагаа нь орчин үеийн ардчиллын чухал хэлбэр болж байгааг дурдсан байна.

Мөн OECD болон НҮБ-аас иргэдийн оролцоог:

- ил тод байдал;
- хариуцлага;
- иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх үндсэн хэрэгсэл гэж үздэг байна.

Монгол Улсад:

- ОНХС-ийн цахим санал;
- өргөдөл гомдлын цахим систем;
- e-Mongolia хэрэглээ өссөн нь иргэд цахим оролцоог хүлээн зөвшөөрч байгааг харуулж байна.

Хүлээн зөвшөөрөгдөх зэрэг нөхцөл:

- иргэдийн санал шийдвэрт хүрэх боломж нэмэгдэнэ;
- ИТХ-ын нээлттэй байдал өснө;
- нутгийн удирдлагад итгэх итгэл нэмэгдэнэ.

Болзошгүй сөрөг нөхцөл:

- улс төрийн зохион байгуулалттай кампанит өргөдөл;
- худал мэдээлэл тараах;
- олон нийтийн түр зуурын сэтгэл хөдлөл давамгайлах эрсдэл.

Иймээс хуулийн төсөл нийтлэг байдлаар хүлээн зөвшөөрөгдөх боломжтой боловч зохисгүй ашиглалтаас хамгаалах зохицуулалт журамлагдах шаардлагатай.

3.5. ЗАРДАЛ

/Тохирох шалгах хэрэгсэл: Зардлын тооцоо хийх/

Төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой шууд болон шууд бус зардлыг үнэлэв.

Шууд зардал:

1. Цахим платформ хөгжүүлэх;
2. Сервер, дата төвийн зардал;
3. Кибер аюулгүй байдал;
4. Системийн засвар үйлчилгээ;
5. Орон нутгийн техникийн тоног төхөөрөмж;
6. Албан хаагчдын сургалт;
7. Иргэдэд мэдээлэл түгээх ажиллагаа.

Шууд бус зардал:

- ИТХ-ын ажлын ачаалал нэмэгдэх;
- өргөдөл боловсруулах хүний нөөц шаардагдах;
- moderation болон шалгалтын ажиллагаа хэрэгтэй болох.

Эерэг эдийн засгийн үр нөлөө:

- цаасан ажиллагаа буурна;
- өргөдөл шийдвэрлэх хугацаа багасна;
- иргэдийн оролцооны зардал буурна;
- ил тод байдал сайжирснаар маргаан буурч болзошгүй.

Иймээс эхний үед төсвийн тодорхой зардал шаардагдах боловч дунд болон урт хугацаанд төрийн үйлчилгээний үр ашиг нэмэгдэх боломжтой гэж үзэв

3.6. ХАРИЛЦАН УЯЛДАА

/Тохирох шалгах хэрэгсэл: Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах/

Хуулийн төслийг дараах хууль тогтоомжтой харьцуулан шалгав:

1. Монгол Улсын Үндсэн хууль;
2. Хууль тогтоомжийн тухай хууль;
3. Цахим гарын үсгийн тухай хууль;
4. Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль;
5. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль;
6. Захиргааны ерөнхий хууль.

Уялдаа хангаж буй хэсэг:

- иргэдийн оролцооны зарчим Үндсэн хуультай нийцэж байна;
- тоон гарын үсгийн хэрэглээ Цахим гарын үсгийн тухай хуультай нийцэж байна;

- цахим мэдээллийн хэрэглээ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуультай уялдаж байна.

Уялдаа дутуу байж болох хэсэг:

1. Хувь хүний мэдээлэл хамгаалах асуудал

Өргөдөлд оролцсон иргэдийн мэдээллийг:

- хэрхэн хадгалах;
- хэн ашиглах;
- хэдий хугацаанд хадгалах нь тодорхойгүй байна.

2. Захиргааны шийдвэрийн үр дагавар

ИТХ өргөдлийг хэлэлцээд:

- татгалзах;
- дэмжих;
- хэсэгчлэн шийдвэрлэх зэрэг тохиолдлын эрх зүйн үр дагавар тодорхойгүй байна.

3. Давхардсан зохицуулалт

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль болон Захиргааны ерөнхий хуультай зарим харилцаа давхцах эрсдэлтэй.

4. Хэрэгжүүлэх журмын шаардлага

Хуулийн төслийн 31.6-д Засгийн газар үлгэрчилсэн журам батлахаар тусгасан нь зөв боловч:

- өргөдөл бүртгэх;
- баталгаажуулах;
- хүчингүй болгох;
- давхардлыг шалгах;
- олон нийтийн мэдээллийн хамгаалалт;
- платформын техникийн стандарт зэрэг асуудлыг нарийвчлах шаардлагатай.

Иймээс:

- хэрэгжүүлэх журмыг нарийвчлах;
- мэдээллийн хамгаалалтын зохицуулалт нэмэх;
- ИТХ-ын шийдвэрийн үр дагаврыг тодорхой болгох шаардлагатай гэж үзэв.

IV. ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЖ ДҮГНЭСЭН БАЙДАЛ

Хуулийн төсөл нь дараах эерэг ач холбогдолтой байна.

- нутгийн өөрөө удирдах ёсыг бэхжүүлэх;
- иргэдийн шууд оролцоог нэмэгдүүлэх;
- цахим ардчиллыг хөгжүүлэх;
- орон нутгийн шийдвэр гаргалтын ил тод байдлыг сайжруулах болно.

Хуулийн төслийн үзэл баримтлал нь Монгол Улсын Үндсэн хууль болон нутгийн удирдлагын шинэчлэлийн бодлоготой нийцэж байна. Мөн олон улсын чиг хандлага, Монгол Улсад хэрэгжиж буй цахим саналын туршлагаас үзэхэд иргэдийн цахим оролцоог өргөжүүлэх бодит хэрэгцээ байгаа нь харагдаж байна.

Гэвч хэрэгжилтийн түвшинд дараах асуудлуудыг илүү нарийвчлан зохицуулах шаардлагатай.

- босго хувь;
- нэр томъёоны тодорхойлолт;
- тухайн платформын мэдээллийн аюулгүй байдал;
- ИТХ-ын хэлэлцэх ажиллагааны журам;
- орон нутгийн техникийн чадавх, интернэт сүлжээний хүчин чадал;
- хүний хувийн мэдээлэл хамгаалах асуудал

Иймээс уг хуулийн төслийг үзэл баримтлалын хувьд дэмжих боломжтой бөгөөд хэрэгжилтийн журам болон техникийн зохицуулалтыг нарийвчлан боловсруулах шаардлагатай гэж дүгнэв.

ЭХ СУРВАЛЖ

I. Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль – 1992 он,
2. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль – 2020 он,
3. Хууль тогтоомжийн тухай хууль – 2015 он,
4. Цахим гарын үсгийн тухай хууль – 2021 он,
5. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль – 2021 он,
6. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль – 2021 он
7. Захиргааны ерөнхий хууль – 2015 он,

II. Ном, гарын авлага, судалгааны эмхэтгэл

1. Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн:
 - “Орон нутгийн түвшинд иргэдийн оролцоог хангах платформын харьцуулсан судалгаа” – 2025 он,
 - “Орон нутгийн төрийн байгууллагуудаас гарч буй шийдвэрт иргэдийн оролцооны байдлын талаарх судалгаа” – 2025 он

III. Цахим эх сурвалж

1. <https://legalinfo.mn/mn/law?page=law&cate=27&active=1&page=1&sort=title&page=1>